



МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ,
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
2015 ОНЫ ЖИЛИЙН
АЖЛЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2015 ОН



ГАРЧИГ

1. Илтгэгчийн үг:	
Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь	2
2. Шүүгч ажилтнуудын бүтээл	4
3. Улсын Дээд шүүхийн 2015 оны ажлын тайлангийн товч танилцуулга	5
4. Эрүүгийн хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	7
5. Иргэний хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	12
6. Захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	18
7. Бусад асуудлаар	23
8. Тамгын газрын ажлын тайлан	25
9. Захиргаа удирдлагын хэлтсийн ажлын тайлан	25
10. Шүүхийн практик судлалын хэлтсийн ажлын тайлан	33
11. Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн ажлын тайлан	36
12. Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн ажлын тайлан	40
13. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн ажлын тайлан	42
14. Ерөнхий шүүгчийн ажлын албаны ажлын тайлан	45
15. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны ажлын тайлан	46
16. Дотоод аудитын албаны ажлын тайлан	49
17. Сургалт семинар	51



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2015 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч: Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь

Эрхэм хүндэт шүүгч, ажилтнуудаа!

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнгөрч буй онд бид шүүхийн шинэтгэлийг амжилттай үргэлжлүүлж, шүүн таслах болон шүүхийн захиргааны ажлын талаар багагүй үр дүнд хүрч, түүнийгээ тайлагнах гэж буйд хувьдаа баяртай байна.

Тодруулбал, өнгөрсөн хугацаанд бид хяналтын шатны шүүн таслах ажиллагаанаас гадна Монголын нийт шүүхийн ерөнхий шүүгч нарын дунд зохион байгуулж ирсэн сургалт, уулзалт-ярилцлагыг сэргээж, шүүн таслах ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар санал бодлоо солилцож, шүүн таслах ажиллагааны асуудал, алдаа зөрчил, ололт амжилтаа эргэн нэг харж, цаашид анхаарах асуудлаа томъёолсон онцлох үйл явдал боллоо.

Түүнчлэн уг уулзалт-ярилцлагын үр дүн болон шүүн таслах ажиллагааны практикийг тухайн шүүх, газар оронд нь судлах, Ерөнхий шүүгчдээс гадна бусад шүүхийн шүүгч нартай уулзалт ярилцлагыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсанд олон шүүх, шүүгчид талархалтай байгааг Та бүхэнд уламжлах нь зүйтэй. Цаашид энэ ажиллагааг тогтмолжуулах, үр өгөөжийг нь дээшлүүлэх нь Улсын Дээд шүүхийн эн тэргүүний зорилт бөгөөд ирэх жилийн уулзалт-ярилцлагыг 2016 оны 2 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд зохион байгуулахаар төвлөгдөж, бэлтгэл ажиллагаа хийгдэж эхэллээ.

Мөн хугацаанд шүүх, шүүгчийн үндсэн хэрэглээ болсон салбарын суурь шинжтэй материаллаг цөөнгүй хууль тогтоомж батлагдсан бөгөөд үүнд тус шүүхийн Танхимын тэргүүнүүд болон шүүгч нарт идэвхитэй ажиллаж, хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд болон шүүхээс хууль хэрэглэх асуудалд зарчмын өөрчлөлт, хүний эрх, эрх чөлөөг шүүхийн журмаар нөхөн сэргээх, баталгаажуулахад дэвшил гарсныг дурьдахад Таатай байна.

Үүгээр зогсохгүй хөрш болон гадаадын бусад улс орнуудын адил шатны шүүхтэй харилцан найрсаг, хамтын ажиллагааг өргөжүүлэх, бэхжүүлэх талд анхаарал хандуулснаар хилийн чанадад шүүгчдийг сургах, мэргэшүүлэх, харилцан туршлага судлах ажиллагаа тогтмолжихын зэрэгцээ бусад сургалтын



шинэ чиглэлүүд нэмэгдсээр байна. Удахгүй бид Испанийн Ванг улсын Дээд шүүх болон Бразил Улсын Дээд шүүхэд энэ зорилгоор шүүгчдийн төлөөллөө илгээх бэлтгэл ажил хангагдаж дууслаа.

Дараагийн зориуд тэмдэглэн хэлэх гэсэн чухал асуудал бол шүүгчийн эдийн засгийн баталгаа, түүнд дотроо шүүгчийн албан тушаалын цалинг эрх зүйн хүрээнд тодорхой болгох, түүнийг өмнөхөөс дордуулахгүй байх талд бид ихээхэн анхаарч холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд энэ талаарх санал, зохих шийдвэрийн төслөө хүргүүлж, яриа хэлэлцээр хийсний дүнд одоо байгаа түвшинд шүүгчийн албан тушаалын цалин хадгалагдлаа.

Өнөөдөр нийгмийн хамгийн их эрэлттэй бөгөөд хялбар аргаар мэдээллэл авах суваг нь цахим ертөнц болсныг анзаарахгүй өнгөрч болохгүй. Өнгөрсөн хугацаанд энэ чиглэлд бид анхаарлаа хандуулж вэб сайтгаа бүрэн шинэчилж, шүүхийн вэб сайгын дэлхийн жишиг, Монголын туршлагад үндэслэн бүрэн хандалттай, Улсын Дээд шүүхийн чиг үүрэг тус бүрээр системчлэгдсэн, шүүхийн шийдвэрийн цахим сангийн давхар баталгаажуулалттай болголоо. Цаашлаад цахим шүүх болох зорилтын хүрээнд цахим хэлбэрээр өргөдөл гомдол, хүсэлт, албан бичиг хүлээн авах болон илгээх техникийн хийгээд эрх зүйн орчны судалгаа хийгдэж байна.

Та бүхний энэхүү нөр их хөдөлмөрийг үнэлж 2015 онд Үндэсний их баяр наадам, Тулгар төр байгуулагдсаны **2224** жил, Их Монгол Улс байгуулагдсаны **809** жил, Ардын хувьсгалын **94** жил, Их эзэн Чингис хааны мэндэлсний **853** жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгч О.Зандрааг “Монгол Улсын Гавьяат хуульч” цолоор, шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн**, Захиргааны хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч **Ш.Даваадулам** нарыг “Алтангадас одон”-оор, эмч А.Ариунболорыг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар тус тус шагнагдсаныг дурьдахгүй байж болохгүй билээ.



Шүүн таслах нөр их ажлын зэрэгцээ шүүгч, ажилтнууд маань:


- “Монгол Улсын Дээд шүүх-2015”;
- “Иргэний хуулийн тайлбар”;
- Иргэний хуулийн 491-494 дүгээр зүйлийн “Гэрээний эрх зүй” ном;
- “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн онол, арга зүйн тайлбар”;
- “Нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал”;
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй: нотлох баримтыг үнэлэх; шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй” сургалтын гарын авлагын 11 дүгээр хэсэг “Тэмдэглэл” сэдэв;
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй: нотлох баримтыг үнэлэх; шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй” сургалтын гарын авлага;
- “Бүтээлийн эмхэтгэл” 2 боть;
- “Эрүүгийн шүүн таслах ажиллагааны алдаа зөрчлийн тойм” зэрэг бүтээл, гарын авлага, альбомыг дангаар болон хамтран бүтээж, нийтийн хүртээл болголоо.






УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Улсын Дээд шүүхийн нийт хүлээж авсан 2349 хэргээс




Шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 1953 хэргээс







Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн болон захиргааны хэргийн танхимуудын 2015 онд хүлээж авсан хэргийг өмнөх онтой харьцуулбал:



2015 онд шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийг өмнөх онтой харьцуулбал:



Улсын Дээд шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн ажлын ачааллыг өмнөх онтой харьцуулбал:






ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ



1.1 Эрүүгийн хэргийн танхим.

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **19** хэрэг дээр хяналтын шатны журмаар эрүүгийн **501**, нийт **520** хэрэг хүлээн авч, **383** хэргийг шүүх хуралдаанаар хянаж шийдвэрлэж, **87** хэргийг хянан буцааж, **43** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо Эрүүгийн хэргийн танхим **7** хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 520 хэргээс



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **54** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **7** хэрэг хэлэлцжээ.

Эрүүгийн хэргийн танхим хяналтын шатны журмаар хүлээн авсан **470** хэргээс нэг шүүгчид **67** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн эрүүгийн **383** хэргийн **50.1** хувь буюу **192** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдэж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, **29.5** хувь буюу **113** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, **20.3** хувь буюу **78** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгожээ.

Өөрчлөлт оруулсан **113** тогтоол, магадлалын **61** хувь буюу **69** шийтгэх тогтоол, магадлалд бусад, **27.4** хувь буюу **31** нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **4.4** хувь буюу **5** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **2.6** хувь буюу **3** нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **2.6** хувь буюу **3** нь Эрүүгийн хуулийн 55¹¹, 62¹




дүгээр зүйлээр, 1.7 хувь буюу 2 нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон 78 тогтоол, магадлалтай хэргээс 51.2 хувь буюу 40 хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр **прокурорт**, 25.6 хувь буюу 20 хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, 11.5 хувь буюу 9 хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгож, 8.9 хувь буюу 7 хэргийг **хэрэгсэхгүй** болгож, 2.5 хувь буюу 2 хэргийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, магадлалыг хэвээр үлдээжээ.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Т.Уранцэцэг 21, шүүгч Б.Бат-Эрдэнэ 79, Б.Батцэрэн 78, Б.Цогт 78, Д.Эрдэнэбалсүрэн 78, Д.Ганзориг 77, Ч.Хосбаяр 59, нийт 470 эрүүгийн хэрэг, Ерөнхий шүүгчийн ажлын алба 43 эрүүгийн хэрэг хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Т.Уранцэцэг 291, шүүгч Д.Ганзориг 333, Д.Эрдэнэбалсүрэн 309, Б.Цогт 297, Б.Батцэрэн 244, Б.Бат-Эрдэнэ 222, ЧХосбаяр 219 удаа тус тус **оролцсоноос**; Танхимын тэргүүн Т.Уранцэцэг 235, шүүгч Б.Батцэрэн 87, Б.Бат-Эрдэнэ 45, Д.Эрдэнэбалсүрэн 9, Д.Ганзориг 5, Ч.Хосбаяр 1, Б.Цогт 1 хэргийн шүүх хуралдааныг тустус **даргалж**;



Танхимын тэргүүн Т.Уранцэцэг **18**, шүүгч Б.Батцэрэн **68**, Б.Цогт **68**, Д.Эрдэнэбалсүрэн **63**, Б.Бат-Эрдэнэ **59**, Д.Ганзориг **58**, Ч.Хосбаяр **49** хэргийг **илтгэсэн** байна.

**Эрүүгийн хэргийн танхимын шүүгчдийн
2015 оны ажлын ачаалал**



Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **383** хэргийн **94.7** хувь буюу **363** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн гомдлоор, **2.8** хувь буюу **11** нь **прокурорын дүгнэлтээр**, **1.5** хувь буюу **6** нь **эсэргүүцлээр**, **0.7** хувь буюу **3** нь иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн өмгөөлөгчийн гомдлоор хэлэлцэгджээ.

Өмнөх онтой харьцуулахад хүлээн авсан эрүүгийн хэрэг **119**-аар буюу **18.8** хувиар, хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэрэг **101**-ээр буюу **20.8** хувиар, нэг шүүгчид ногдох хэрэг **32**-оор буюу **32.3** хувиар тус тус буурсан байна.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн Т.Уранцэцэг **3**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **20**, Д.Ганзориг **19**, Д.Эрдэнэбалсүрэн **15**, Б.Батцэрэн **10**, Ч.Хосбаяр **10**, Б.Цогт **10** хэргийг хянан, дээд шатны прокурор эсэргүүцлээ татан авсан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн эсвэл гомдол гаргах хугацаа хэтэрсэн гэсэн үндэслэлүүдээр тус тус буцаасан байна.

Тус танхим 2015 онд нийт **114** албан бичиг, **45** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Т.Уранцэцэг **54** албан бичиг, **19** өргөдөл, гомдол, шүүгч Б.Батцэрэн **26** албан бичиг, **10** өргөдөл, гомдол, Б.Цогт **9** албан бичиг, **6** өргөдөл, гомдол, Д.Ганзориг **6** албан бичиг, **3** өргөдөл, гомдол, Д.Эрдэнэбалсүрэн **6** албан бичиг, **1** өргөдөл, гомдол, Б.Бат-Эрдэнэ **5** албан бичиг, **1** өргөдөл, гомдол,



Ч.Хосбаяр **4** албан бичиг, **3** өргөдөл, гомдол, С.Батдэлгэр **4** албан бичиг, **2** өргөдөл, гомдол /*Ерөнхий шүүгчийн ажлын албанд 67/* тус тус хянан шийдвэрлэж, одоо **17** албан бичиг, **9** өргөдөл гомдлын үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **344** гарснаас Танхимын тэргүүний “шүүхийн харьяалал тогтоох тухай” захирамж **58**, бусад захирамж **286**, мэдэгдэх хуудас **107** гарсан байна.




ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМ



1.2. Иргэний хэргийн танхим

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **33** хэрэг дээр хяналтын шатны журмаар **1195**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **153**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **54**, нийт **1435** хэрэг хүлээн авч, **1155** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **157** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, **53** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар хэлэлцэж, **13** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалтаж, **17** хэргийн харьяаллыг тогтоож, одро **40** хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 1435 хэргээс



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **84** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **14** хэрэг хэлэлцжээ.

Иргэний хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **1208** хэргээс нэг шүүгчид **151** хэрэг тус тусногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний **1155** хэргийн **55.7** хувь буюу **643** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, **12** хувь буюу **139** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, **21.7** хувь буюу **250**



хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **10.6** хувь буюу **123** хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан **250** шийдвэр, магадлалын **54.4** хувь буюу **136** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **45.6** хувь буюу **114** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **139** шийдвэр, магадлалтай хэргээс **74.1** хувь буюу **103** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **25.9** хувь буюу **36** хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан **139** хэргийн **68.3** хувь буюу **95** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **31.7** хувь буюу **44** нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **65**, шүүгч Г.Цагаанцоож **194**, Ц.Амарсайхан **190**, Х.Эрдэнэсүвд **188**, Д.Цолмон **184**, Г.Алтаннимэг **139**, П.Золваяа **139**, Б.Ундрах **139** хэрэг хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг



Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **990**, шүүгч Г.Цагаанцоож **888**, Х.Эрдэнэсүвд **816**, Д.Цолмон **805**,




Ц.Амарсайхан **802**, Б.Ундрах **634**, Г.Алтанчимэг **581**, П.Золзаяа **524** удаа **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **826**, шүүгч Б.Ундрах **161**, Ц.Амарсайхан **117**, Г.Цагаанцож **95**, Х.Эрдэнэсүвд **6**, П.Золзаяа **3** хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **50**, шүүгч Г.Цагаанцож **193**, Ц.Амарсайхан **188**, Х.Эрдэнэсүвд **184**, Д.Цолмон **182**, Г.Алтанчимэг **138**, Б.Ундрах **137**, П.Золзаяа **136** хэргийг **илтгэсэн** байна.

Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2015 оны бүтэн жилийн ажлын ачаалал



Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **399** нэхэмжлэгчийн, **742** хариуцагчийн, **13** гуравдагч этгээдийн, **1** прокурорын /эсэргүүцлээр/ гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Өмнөх онтой харьцуулахад хүлээн авсан иргэний хэрэг **375**-аар буюу **26.8** хувиар, хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэрэг **330**-аар буюу **27.3** хувиар, нэг шүүгчид ногдох хэрэг **33**-аар буюу **22.5** хувиар тус тус өссөн байна.



Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **1155** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

- Иргэний хуулиар **772**;
- Хөдөлмөрийн тухай хуулиар **247**;
- Гэр бүлийн тухай хуулиар **44**;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **41**;
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **5**;
- бусад хуулиар **46** хэргийг хянан шийдвэрлэжээ.

Мөн энэ хугацаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **819.446.139** /найман зуун арван есөн сая дөрвөн зуун дөчин зургаан мянга нэг зуун гучин ес/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **233.676.976** /хоёр зуун гучин гурван сая зургаан зуун далан зургаан мянга есөн зуун далан зургаа/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим 2015 оны бүтэн жилд нийт **72** албан бичиг, **71** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **24** албан бичиг, **29** өргөдөл гомдол, Г.Цагаанцоож **14** албан бичиг, **11** өргөдөл гомдол, шүүгч Б.Ундрах **7** албан бичиг, **5** өргөдөл гомдол, Д.Цолмон **9** албан бичиг, **4** өргөдөл гомдол, Ц.Амарсайхан **7** албан бичиг, **3** өргөдөл гомдол, Х.Эрдэнэсүвд **1** албан бичиг, **5** өргөдөл гомдол, Г.Алтанчимэг **2** албан бичиг, **3** өргөдөл гомдол, П.Золзаяа шүүгч **2** албан бичиг, **3** өргөдөл, гомдол тус тус хянан шийдвэрлэж, **4** албан бичиг, **6** өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэхээр Тамгын газар болон бусад танхимд шилжүүлж, одро **2** албан бичиг, **2** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Иргэний хэргийн танхим 2015 оны бүтэн жилийн байдлаар Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:

- Монгол Ардын намын үндсэн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Монголын нэг хүний намыг 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр, Монголын хүний төлөө намыг 2015 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 03 дугаар тогтоолоор тус тус улсын бүртгэлд шинээр бүртгэхээс татгалзаж;
- Иргэний зориг ногоон намын дүрмийн нэмэлт өөрчлөлтийг 2015 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор бүртгэж;
- Монголын залуучуудын нэгдсэн намыг 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар, Ард түмнээ хайрлая намыг 2015 оны 05 дугаар



сарын 22-ны өдрийн 06 дугаар тогтоолоор тус тус улсын бүртгэлд шинээр бүртгэхээс татгалзаж;

- Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намыг 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 07 дугаар тогтоолоор улсын бүртгэлд шинээр бүртгэж;
- Хөдөлмөрийн үндэсний намын дарга болон мөрийн хөтөлбөрт оруулсан уриа үгийг “Монгол хүний төлөө” гэж өөрчилснийг 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 08 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Ард түмнээ хайрлая намыг 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд шинээр бүртгэж;
- Ардчилсан намын ҮЗХ-ны 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн ээлжит бус 44 дүгээр хурлаар намын даргаар Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, 1 дүгээр 40 мянгат, 52 дугаар байр, 7 тоотод оршин суух, Шарнууд овогт Зандаахүүгийн Энхболд сонгогдсоныг улсын бүртгэлд Улсын Дээд шүүхийн 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолоор бүртгэж;
- Бие Даагчдын Нэгдсэн намыг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 11 дүгээр, Нэгдмэл Монгол намыг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 12 дугаар тогтоолоор тус тус улсын бүртгэлд шинээр бүртгэхээс татгалзаж;
- Хөдөлмөрийн үндэсний намын дүрмийн болон мөрийн хөтөлбөрийн өөрчлөлтийг 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолоор бүртгэж;
- Бие даасан намыг 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 14 дүгээр, Эрх зүйг эрхэмлэх намыг 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15 дугаар, Нэгдмэл Монгол намыг 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар тогтоолоор тус тус улсын бүртгэлд шинээр бүртгэхээс татгалзсан байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **1350** гаргаснаас Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **1022**, “Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай” **308**, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **8**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” **8**, “харьяалал тогтоох” **4** шүүгчийн захирамж тус тус гарчээ.




ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМ



1.3. Захиргааны хэргийн танхим

Захиргааны хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **12** хэрэг /хяналтын журмаар гомдол гаргасан 10, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 2 хэрэг/ дээр 2015 онд хяналтын шатны журмаар **376** захиргааны хэрэг, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **46**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **18**, Шүүхийн ёс зүйн хорооны гомдолтой **12**, нийт **464** хэрэг хүлээн авч, **362** хэргийг хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар, **17** хэргийг хуралдаанд оролцуулахгүйгээр, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **14** хүсэлтийг шийдвэрлэж, **48** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо **23** хэргийн /хяналтын журмаар гомдол гаргасан 19, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах 4 хэрэг/ үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 464 хэргээс



Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **50** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **7.5** хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **393** хэргээс нэг шүүгчид **56.1** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын шатны журмаар хэлэлцэгдсэн **362** хэргийн **65.7** хувь буюу **238** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **16.5**



хувь буюу **60** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **17.6** хувь буюу **64** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.


Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон **64** хэргийн **32.8** хувь буюу **21** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **12.5** хувь буюу **8** хэргийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, **54.6** хувь буюу **35** хэргийн магадлал хүчингүй, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулсан байна.

Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан **60** хэргийн **31,6** хувь буюу **19** нь хууль буруу хэрэглэсэн, **26,6** хувь буюу **16** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **41,6** хувь буюу **25** шийдвэр, магадлалд бусад өөрчлөлт оруулсан.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **18** хэргийн **13** хэргийн хүсэлтийг хангаагүй, **1** хэргийг хүсэлтийг хэлэлцэхээс татгалзаж буцаан, **4** хэргийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн М.Батсуурь **1**, шүүгч Ц.Сумъяа **62**, Д.Мөнхтуяа **60**, Л.Атарцэцэг **58**, О.Зандраа **58**, Ч.Тунгалаг **58**, Х.Батсүрэн **57**, П.Соёл-Эрдэнэ **39** захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч Х.Батсүрэн **190**, Ч.Тунгалаг **189**, Ц.Сумъяа **173**, Д.Мөнхтуяа **163**, О.Зандраа **143**, Л.Атарцэцэг **140**, П.Соёл-Эрдэнэ **127** удаа тус тус оролцож,



Танхимын тэргүүн М.Батсуурь **337**, шүүгч Ц.Сумъяа **24**, Х.Батсүрэн **7**, Ч.Тунгалаг **6**, Л.Атарцэцэг **1** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Шүүгч Ц.Сумъяа **59**, Л.Атарцэцэг **57**, Д.Мөнхтуяа **57**, О.Зандраа **56**, Х.Батсүрэн **53**, Ч.Тунгалаг **55**, П.Соёл-Эрдэнэ **38** хэрэг тус тус **илтгэсэн** байна.

Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн 2015 оны ажлын ачаалал



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн нийт хэргийн **92** нь нэхэмжлэгчийн, **64** нь хариуцагчийн, **30** нь гуравдагч этгээдийн, **127** нь хэргийн оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, **37** нь өмгөөлөгчийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Өмнөх онтой харьцуулахад хүлээн авсан захиргааны хэрэг **54**-өөр буюу **12.2** хувиар, хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэрэг **56**-ээр буюу **18.3** хувиар, нэг шүүгчид ногдох хэрэг **12**-оор буюу **27.3** хувиар тус тус өссөн байна.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **362** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

- Төрийн албаны маргаан **100**;
- Газрын маргаан **88**;
- Татварын маргаан **38**;
- Ашигт малтмалын маргаан **16**;
- Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалтай **12**;
- Төрийн хяналт шалгалт **10**;
- Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан **9**;



- Орон сууц хувьчлалтай холбоотой маргаан **6**;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан **2**;
- Сонгуулийн маргаан **1**;
- Бусад маргаан **80** байна.

Мөн хугацаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **18,392,400** /арван найман сая гурван зуун ерэн хоёр мянга дөрвөн зуу/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **4,773,600** /дөрвөн сая долоон зуун далан гурван мянга зургаан зуу/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим **2015 онд** нийт **49** албан бичиг, **23** өргөдөл, гомдол хүлээн авснаас: Танхимын тэргүүн М.Батсуурь **25** албан бичиг, **14** өргөдөл гомдол; Л.Атарцэцэг **4** албан бичиг, **4** өргөдөл гомдол; Д.Мөнхтуяа **4** албан бичиг, **2** өргөдөл гомдол; Ц.Сумъяа **6** албан бичиг; Ч.Тунгалаг **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол; О.Зандраа **3** албан бичиг, **1** өргөдөл гомдол; Х.Батсүрэн **3** албан бичиг; П.Соёл-Эрдэнэ **1** албан бичиг, **1** өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэсэн байна.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол **699** гаргаснаас бүрэлдэхүүн томилох тухай **481**, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **127**, “улсын тэмдэгтийн хураамж буцаах тухай” захирамж **58**, “шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлтийг шийдвэрлэх тухай” шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж **14**, “гомдол хэлэлцэхээс татгалзах тухай” **7**, “гомдол гаргаагүйд тооцох тухай” **7**, бусад захирамж, тогтоол **5** гарсан байна.



ХОЁР. БУСАД АСУУДЛААР

Энэ хугацаанд Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид

- Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд;
- Улсын Их Хуралд “Захиргааны хариуцлагын тухай хууль” болон “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн зарим зүйл заалтад өөрчлөлт оруулж, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал;
- Үндсэн Хуулийн Цэцэд “Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хууль”-ийн зарим зүйл, хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцээгүй талаар санал.

Иргэний хэргийн танхимын шүүгчид

- Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон дагалдах хуулийн төсөлд;
- Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд;

Захиргааны хэргийн танхимын шүүгчид

- Захиргааны ерөнхий хуулийн төсөлд;
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд тус тус санал өгч, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүргээ хэрэгжүүлжээ.

Улсын Дээд шүүхийн цүүгч нар

Харин Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Т.Уранцэцэг**, шүүгч **Б.Батцэрэн**, **Б.Цогт**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар “Гэмт хэргийн тухай”, “Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай”, “Эрүүгийн хууль”, “Зөрчлийн тухай”, “Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай” хуулийн ажлын хэсгийн гишүүнээр;

Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Т.Уранцэцэг**, шүүгч **Д.Цолмон** нар “Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй” сэдвээр шүүгчийн сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах ажлын хэсэгт гишүүнээр,

Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Т.Уранцэцэг** “Шүүхийн мэргэшлийн хороо”-ны даргаар, шүүгч **Б.Батцэрэн**, **Б.Бат-Эрдэнэ** нар гишүүнээр;



Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр** Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ иргэний хэргийн мониторингийн ажлын хэсгийн ахлагчаар; “**Хууль тайлбарлах онол арга зүй**” хичээлийн хөтөлбөр, сэдэв боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тайлбарлах” хичээлийн хөтөлбөр, гарын авлага боловсруулах, “Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийг зүгшрүүлэх” ажлын хэсгийн ахлагчаар;

“**Захиргааны ерөнхий хууль**”-ийн ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна.

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **О.Зандраа**, **П.Соёл-Эрдэнэ** нар “**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль**”-ийн ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Л.Атарцэцэг** “**Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийг зүгшрүүлэх**” ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Х.Батсүрэн** “**Хуульчийн эрх зүйн байдлын тухай**” хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Б.Батцэрэн** “**Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийг хэрэгжүүлэх**” ажлын хэсгийн ахлагчаар, шүүгч **Ч.Хосбаяр** ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **О.Зандраа** “**Нотариатын тухай**” хуулийн ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Ц.Амарсайхан** “**Шүүхийн сонгомол шийдвэр шалгаруулсан үнэлгээний нэгтгэл**”-ийн ажлын хэсгийн гишүүнээр;

Шүүгч **Ч.Тунгалаг** “**Татварын багц хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай**” хуулийн дэд ажлын хэсгийн гишүүнээр;

Танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **П.Золзаяа** нар Нотариатчийн танхимын Мэргэшлийн хорооны гишүүнээр;

Шүүгч **Б.Бат-Эрдэнэ** Хууль сахиулах их сургуулийн докторын зэрэг хамгаалах зөвлөл, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль, Шихихутуг хууль зүйн дээд сургууль, Билэг дээд сургууль, Тагнуулын үндэсний академийн магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр;

Шүүгч **Д.Цолмон** Шүүхийн Ерөнхий зөвлөлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр тустус ажилласан байна.

Мөн Эрүүгийн хэргийн танхим өнгөрсөн хугацаанд “**Шүүн таслах ажиллагааны алдаа, зөрчлийн талаар**” тоймыг боловсруулж, холбогдох шүүх, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ.



ТАМГЫН ГАЗРЫН АЖЛЫН ТАЛААР

1. Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах чиглэлээр:

Шүүхийн тамгын газар нь Шүүхийн тухай багц хууль, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохих ёсоор гүйцэтгэх, Шүүхийн захиргааны тухай хуулийн **6-12** дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар анхааран ажиллаа.

Захиргаа удирдлагын хэлтсээс Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2014 оны байдлаар шинэчлэгдсэн маягыг дахин гаргуулан авч, **25** шүүгчийн материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Сахилгын хороонд, **1** хүний материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ажлын албанд, 45 захиргааны албан хаагчийн материалыг Тамгын газарт зохих журмын дагуу хадгалж, цахим хэлбэрээр шинэчлэн гаргуулсан байна.

Мөн захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн **17** хүний хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг “**Авлигатай тэмцэх газар**”-т хянуулахаар хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авч, Тамгын газрын даргад танилцуулжээ.

Түүнчлэн “**Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан**”-г шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөл, Шүүхийн ерөнхий зөвлөлд тогтсон хугацаанд нь хүргүүлсэн байна.

Тулгар төрийн 2224 жилийн ой, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 94 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг буулган Улсын Дээд шүүхийн шүүгч **О.Зандрааг** “Монгол Улсын Гавъяат хуульч” цолоор, шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн**, Захиргааны хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч **Ш.Даваадулам** нарыг “Алтангадас” одонгоор, эмч **А.Ариунболорыг** “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар шагнагдах ажлыг зохион байгууллаа.

“Билгийн тооллын хаврын тэргүүн сар - Цагаан сарын баяр”, “Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр”, “Хүүхдийн баяр”, “Үндэсний их баяр наадмын өдөр”,




“Их Эзэн Чингис хааны өдөр”, “Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр” “Шинэ жилийн баярын өдөр” болон бусад тэмдэглэлт баяр, бүх нийтийн амралтын өдрүүдэд тухай бүр арга хэмжээг зохион байгуулж, Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор Тамгын газрын даргын **8** удаагийн тушаалаар **11** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын Дээд шүүхэд бүртгүүлж ... өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэнэ.” гэж заасны дагуу Тамгын газрын даргын тушаалаар 2013 оноос одоог хүртэл **2181**, энэ онд **262** хуульчдад өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг тус тус нээж, гэрчилгээ, үнэмлэх олгоод байна.

Тайлангийн хугацаанд **288** өргөдөл гомдол, **738** албан бичиг, **2373** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгч, Тамгын газрын даргад танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **3416** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.


Өмнөх онтой харьцуулж үзвэл:



Тамгын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөв лөгөөнд тусгагдсны дагуу “Онлайнсолюшнс” компанитай хамтран Улсын Дээд шүүхийн цахим хуудсыг шинэчлэлээ. Ингэснээр хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, шүүгчийн тусгай санал, Улсын төрийн намын бүртгэл, Өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх



эрхийн бүртгэл, цагаатгалын бүртгэлийг цахим санд байршуулж, шүүх олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байлгах, шүүгч, эрдэмтэн, багш, судлаач, шинжээч, хуульчдад судалгааны ажил хийх, оюутан сурагчдад гарын авлага болгох, хуулийг нэг мөр, зөв хэрэглэх, жишиг тогтоох ач холбогдолтой болсон байна. Цаашид цахим шүүх болох зорилт тавьж, иргэдээс болон хуулийн этгээдээс цахим хэлбэрээр өргөдөл, гомдол, албан бичиг хүлээн авч, илгээх программ хангамжийг боловсруулж байна.



Улсын Дээд шүүхээс анхан болон давж заалдах шатны Ерөнхий шүүгч нарт зориулсан “Монгол Улс дахь шүүн таслах ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт уулзалт-ярилцлага сургалтыг 2015 оны 2 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд “Чингис хаан” зочид буудлын сургалтын танхимд зохион байгуулсан бөгөөд нийт 78 шүүхийн Ерөнхий шүүгчид хамрагдсан байна. Уулзалт-ярилцлагыг Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын тэргүүн, шүүгчид удирдан явуулсан бөгөөд Шүүхийн тухай багц хуулийн хэрэгжилт ба Эрүүгийн шүүн таслах ажиллагааны алдаа зөрчлийн тойм, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь алдаа зөрчлийн тойм, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь алдаа зөрчлийн тойм Дээд шүүхээс шүүн таслах ажиллагааны талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаа, шүүн таслах



ажиллагааны практик, түүнд оршиж буй нийтлэг алдаа зөрчил, цаашид анхаарах зарим асуудлын талаар харилцан санал солилцжээ.





Түүнчлэн 2015 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс 6 дугаар сарын 16-ны өдрүүдэд анхан болон давж заалдах шатны Ерөнхий шүүгч, шүүгч нарт “Шүүн таслах ажиллагаа, хууль хэрэглэх, тайлбарлах, шүүхээс гаргах шийдвэрийн талаарх практик” сэдэвт уулзалт-ярилцлагыг зүүн, говийн, төвийн, хангайн, баруун гэсэн нийт 5 бүсэд хуваан зохион байгуулсан бөгөөд нийт 78 шүүхийн 400 гаруй шүүгч хамрагдсан байна. Уулзалт-ярилцлагыг Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын тэргүүн, шүүгчид удирдан явуулсан бөгөөд Шүүхийн тухай багц хуулийн хэрэгжилт ба шүүн таслах ажиллагаа, шинээр боловсруулагдаж буй Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шалгах тухай, Захиргааны ерөнхий хууль зэрэг материаллаг болон процессийн хуулиудын үзэл баримтлал, Дээд шүүхээс шүүн таслах ажиллагааны талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаа, шүүн таслах ажиллагааны практик, түүнд оршиж буй нийтлэг алдаа зөрчил, цаашид анхаарах зарим асуудлын талаар харилцан санал солилцжээ.





Энэ хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн “Улсын үзлэг явуулах тухай” 195 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн “Улсын үзлэг явуулах төв комиссын бүрэлдэхүүн, удирдамжийг батлах тухай” 124 дүгээр захирамж, Хууль зүйн сайдын баталсан улсын үзлэг явуулах хуваарийн дагуу 2015 оны 9 дүгээр сарын 08-14-ний өдрүүдэд комиссын бүрэлдэхүүн ажиллажээ.

Тус үзлэгийн хүрээнд Улсын Дээд шүүхийн архивын өрөөнд шаардагдах техник хэрэгсэл /галын дрехиолол, чийгшүүлэгч зэрэг/-ийг шинээр байршуулж хадгалалт, хамгаалалтад тавигдах шаардлагыг зохих түвшинд хангаж ажилласан, байгууллагын дэргэдэх “**Баримт бичиг нягтлан шалгах комисс** /ББНШК/-ын үйл ажиллагаа тогтмолжиж, асуудлыг бодитойгоор хэлэлцэж шийдвэрлэсэн, байгууллагын архивт хадгалагдаж буй 1996-2012 оны байнга хадгалах баримтын данс, 1994-2012 оны түр хадгалах баримтын бүртгэл, 1987-2012 оны 70 жил хадгалах баримтын бүртгэл, 1996-2010 оны устгах хэргийн актыг тус тус үйлдэж, Үндэсний төв архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс /ББНШАЗК/-ын хурлаар хэлэлцүүлж батлуулсан нь онцлог болсныг комисс дүгнэн, сайшааж, нийт дүнгээр 86.5 буюу “В” үнэлгээ авсан байна.

Улсын Дээд шүүхийн Тамгын газраас шүүгч, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ТОС Корпорацигай хамтран “**Буянт-Ухаа 2**” орон сууцны хорооллоос Улсын Дээд шүүхэд 5 айлын орон сууцны квот хуваарилж, шүүгч, ажилтнуудыг сонгон шалгаруулаад байна.



Мөн Төв аймгийн Баяндэлтэр сумын “**Мэлзийн ам**”-д 10 айлын зуслангийн газар, Багануур дүүргийн “**Хуцаагийн ам**”-д шүүхийн сургалт, судалгааны хүрээлэн барих 1 га газрын асуудлыг тус тус шийдвэрлүүлгээ.

Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “**Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажил мэргэжлийн уралдаан, спортын өдөрлөг-2015**”-д амжилттай оролцож, шатрын тэмцээний эмэгтэйчүүдийн төрөлд Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах ахлах шинжээч **Э.Энжаргал** тэргүүн байр, теннисны эрэгтэйчүүдийн төрөлд Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах **Т.Жавхлантагс** дэд байр, сагсан бөмбөгийн тэмцээний эмэгтэйчүүдийн төрөлд Улсын Дээд шүүхийн эмэгтэй баг 3 дугаар байр тус тус эзэлсэн бол 2015 оны 11 дүгээр сарын 13-22-ны өдрүүдэд Хуулийн төв байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг “**Шилжин явах цом**”-ын төлөө спортын наадам 5 төрөлт тэмцээнд Улсын Дээд шүүхийн баг тамирчид багийн нийт оноогоор **гуравдугаар** байрт шалгарсан амжилт үзүүлжээ.

Мөн Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын эрүүл мэнд, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр “**Говь ресорт**” амралтын газарт цасны баярыг, 2015 оны 10 дугаар сарын 08-10-ны өдөр Улсын Дээд шүүхийн Тамгын газар, Залуучуудын зөвлөлөөс уламжлал болгон зохион байгуулдаг гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнийг Орхон аймгийн “**Сэлэнгэ**” амралтын баазад амжилттай зохион байгууллаа.

Түүнчлэн Шүүхийн тухай багц хууль болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шинэчлэн батлагдсан дүрэм, журамд нийцүүлэн Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын өдөр тутамын үйл ажиллагаанд дагаж мөрдөх заавар, дүрэм, журам, стандартуудыг боловсруулж, Ерөнхий шүүгчийн захирамж, Тамгын газрын даргын тушаалаар баталлаа. Тодруулбал, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2015 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 42, 44, 45, 46, 47, 48, 49 дүгээр захирамжаар батлагдсан “**Ерөнхий шүүгчийн ажлын албаны ажиллах журам**”, “**Улсын Дээд шүүхийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам**”, “**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгасан тухай үнэмлэх олгох журам**”, “**Архивын ажлын үндсэн заавар**”, “**Архивын үйлчилгээний хөлс авах журам**”, “**Улсын Дээд шүүхэд ирсэн хэрэг болон иргэд, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, хүсэлт, гомдлыг хүлээн авах, хуваарилах, шийдвэрлэх журам**”, “**Практик судлалын хэлтсийн ажиллах журам**”, “**Улсын Дээд шүүхийн Хөдөлмөрийн дотоод журам**”, Тамгын газрын даргын 2015 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 118, 119, 120, 121, 123 дугаар тушаалаар батлагдсан “**Улсын Дээд шүүхэд**



автомашин хэрэглэх журам”, “Улсын Дээд шүүхийн албаны гар утас хэрэглэх журам”, “Халамжийн санг бүрдүүлэх, хадгалах, зарцуулах журам”, “Ахмадын зөвлөлийн үйл ажиллагааны журам”, “Шүүх хуралдааны үйл явцыг ажиглах, мэдээлэл авах ажиллагааг зохион байгуулах заавар”, “Ажлын байрны тодорхойлолт батлах тухай”, мөн Улсын Дээд шүүхийн Стратеги төлөвлөгөө болон сургалт, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг тус тус боловсруулаад байна.

2. Шүүхийн хүний нөөцийн чиглэлээр:

Тайлангийн хугацаанд **Н.Булгамааг** Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн даргын, **Н.Түмэнбаярыг** Дотоод аудитын албаны даргын, **Х.Бадамжаргалыг** Дотоод аудитын ажил хариуцсан ахлах шинжээчийн, **Ж.Эрдэнийг** Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээчийн, **А.Баярцэцэгийг** Гэмт хэргийн тухай хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээчийн, **Б.Энхбатыг** Захиргааны хэргийн тухай хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээчийн, **Ч.Батням, Г.Болдбаяр С.Цэрэндулам, Л.Хэрлэнчимэг, Б.Содгэрэл, Ч.Сэлэнгэмөрөн,** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн, **Б.Марал-Эрдэнийг** Хууль тогтоомжийн системчлэл хариуцсан ахлах мэргэжилтний, **И.Бямбасүрэн, Б.Наранжаргал, Ш.Мөнхжаргал, Ц.Шагдарсүрэн** нарыг шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд, **А.Ичинхорлоог** няравыг, **Ч.Одгэрэлийг** Тамгын газрын жолоочийн, **Э.Өлзийбаярыг** цахилгаанчны, **Г.Мөнхцэцэг, Л.Отгонсүрэнг** үйлчлэгчийн ажилд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн тус тус томилж, өөрийн хүсэлтээр төрийн албанаас Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээч **С.Сундуйжав,** Дотоод ажил хариуцсан шинжээч **С.Дархантөгс,** Шүүгчийн туслах-шинжээч **Ц.Амармэнд, Г.Амартүвшин,** Иргэний хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээч **М.Цэнгүүн,** Хууль тогтоомжийн системчлэл хариуцсан ахлах мэргэжилтэн **Б.Мөнхсайхан,** нярав **Б.Отгонцэрэн** нарыг чөлөөлж, сахилгын зөрчил гаргасан Тамгын газрын жолооч **Ж.Алтангэрэл,** үйлчлэгч **Д.Оюунчимэг** нарыг үүрэгт ажлаас нь халсан байна.

Мөн Тамгын газрын даргын тушаалаар шүүгчийн туслах-шинжээч **Д.Алтанцэцэгийг** Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн, Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан ахлах референт **Д.Тулгыг** Гадаад харилцаа хамтын ажиллагааны



албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн **И.Бямбасүрэн**, **Ц.Шагдарсүрэн** нарыг Шүүгчийн туслах-шинжээчийн албан тушаалд дэвшүүлэн ажиллуулжээ.

Тайлангийн хугацаанд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 58 дугаар зарлигаар **Г.Алтанчимэг**, **П.Золзаяа**, **П.Соёл-Эрдэнэ**, **Ч.Хосбаяр** нарыг Улсын Дээд шүүхийн шүүгчээр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 167 дугаар зарлигаар Шүүгчийн туслах-шинжээч **И.Амартөгс** Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчээр, Шүүгчийн туслах-шинжээч **С.Нямсүрэн**, **Н.Хангал** нарыг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчээр томилжээ.

Шүүгчийн туслах-шинжээч **С.Золбоо**, **Г.Мөнхсайхан**, **Б.Өлзийнхишиг** нарын төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг,

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн туслах-референт **Б.Бямбаабаатар**, Мэдээлэл лавлагааны ажил хариуцсан ахлах шинжээч **Б.Чимгээ**, Шүүгчийн туслах-шинжээч **И.Амартөгс**, **Ч.Нямсүрэн**, **Т.Майцэцэг**, Цахим засаглал, хэвлэл мэдээллийн ажил хариуцсан шинжээч **Д.Оюунчимэг** нарын зэрэг дэвийг тус тус шинээр болон нэмэгдүүлэн олгожээ.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу давхардсан тоогоор 68 хүний үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх, **23** хүний хөдөлмөрийн гэрээг байгуулах ажлыг хагас, бүтэн жилээр зохион байгуулжээ.

Мөн Дотоод ажил хариуцсан шинжээч **С.Дархантөгс**, шүүгчийн туслах-шинжээч **Д.Даваадорж**, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга **Б.Дүүрэнжаргал**, **С.Баяртуяа**, **Т.Өлзийтүвшин** нарын Төрийн албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр зохион байгууллаа.

3. Шүүхийн практик судлах чиглэлээр:

Тус хэлтсээс тойм, зөвлөмж гаргах, эрх зүйн онол, хууль зүйн харьцуулалт, шүүхийн практикийн тоон болон чанарын **38** судалгааны ажил хийж, тайлан, танилцуулга бичиж хүргүүлсэн байна. Тухайлбал:

Улсын Дээд шүүхийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, шүүгч, захиргааны ажилтнуудын хэрэгцээнд тулгуурлан нийт 28 судалгааг гаргасан байна.



Түүнчлэн төрийн бусад байгууллагын захиалга, албан тоот, хүсэлтээр УИХ-ын Тамгын газар, УИХ-ын гишүүдэд-3(Албан тушаалтан, ажилтныг ажил эрхлэхээс чөлөөлөх, огцруулах, түдгэлзүүлэх, татгалзах тухай асуудлын эрх зүйн зохицуулалтын судалгаа, Гадаад улс орнуудын хууль тогтоомжийн мониторингийн эрх зүйн журамлалтын судалгаа, Гэрч хохирогчийг хамгаалах, тусгалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр дагалдах найман төрлийн төслийн шинжилгээ), Ерөнхийлөгчийн Тамгын газарт-3(Ерөнхийлөгчийн захиалгаар Үндсэн хуулийн цэцээс зохион байгуулж байгаа Үндсэн хуулийн хэрэгжилтийн судалгааны “Шүүх эрх мэдэл” бүлгийн судалгаа”-танилцуулга, “2014 онд шүүхээр шийдвэрлэсэн авилгын хэрэг, авилгын хэрэгт ял шийтгүүлсэн гадаадын иргэний дэлгэрэнгүй судалгаа, судалгаатай холбоотой танилцуулга”, Улсын Дээд шүүхээс 2014 онд хянан шийдвэрлэсэн “Татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэргийн судалгаа, танилцуулга”, Гадаадын иргэд, аж ахуйн нэгжээс татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэргийн судалгаа), Засгийн газарт-3 (Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгийн төслийн шинжилгээ, танилцуулга, Эрүүгийн шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн шинжилгээ танилцуулга, Олон улсын эрүүгийн эрх зүйн болон Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн харьцуулсан шинжилгээ танилцуулга) нийт 9 судалгаа гаргажээ.

Монгол Улсын шүүхээс хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны 2008-2013 оны дэлгэрэнгүй судалгааг нэгтгэн боловсруулж, Улсын Дээд шүүхийн мэдээлэл сэтгүүлд хэсэгчлэн хэвлэн нийтэлжээ.

Мөн Эрүүгийн хэргийн танхимтай хамт ран “**Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл**”, “**Эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл**”, “**Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл**”, “**Хүний эрхийн тухай хуулийн төсөл**”, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”, “**Олон улсын гэрээний тухай хуулийн төсөл**” зэрэг хуулийн төсөлд дэлгэрэнгүй санал гаргажээ.

Хэлтсийн дарга **Ч.Нямсүрэн** Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан “**Төрийн өндөр албан тушаалтны хариуцлагын тухай хуулийн төсөл**”-ийн ажлын хэсэгт орж ажилласан байна. Мөн Олон Улсын эрдэм шинжилгээний бага хуралд 3 илтгэл (“*Монгол улс дахь эрүүгийн эрх зүйн шинэчлэл: өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага*” Олон улсын эрдэм шинжилгээний хурал // Монголын төр эрх зүй сэтгүүл. УБ., 2015 он N3 Монгол улсын үндсэн хууль дахь эдийн засгийн эрх, эрх чөлөө: тулгамдсан асуудал//Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал УБ., 2015 он, Наториатын шүүх түүний хөгжлийн



чиг хандлага// Монгол Улсын Нотариат-90 УБ.,2015) тавьж хэлэлцүүлж, гадаад дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүл, эмхтгэлд хэвлүүлжээ.

Мөн “Монгол улс дахь шүүн таслах ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт сургалт уулзалт-ярилцлагад зориулж, “2010-2014 онд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шүүхийн шатан дахь алдаа зөрчил, анхаарах асуудал” дэлгэрэнгүй лекц бичжээ.

“Монголын төр эрх зүй” сэтгүүлийн I,II,III дугаар, “Улсын Дээд шүүхийн мэдээлэл” зэрэг улирал дутмын сэтгүүлийн IV, I,II дугаарыг гаргаж нийтийн хүртээл болгожээ.

Тус хэлтсийн шинжээчид эрүү, иргэний болон захиргааны хэргийн хяналтын шатны шүүхээр хянагдсан хэргүүдийн өөрчлөгдсөн, хүчингүй болсон шалтгаан нөхцлийг 2014, 2015 оны хагас жилийн байдлаар судалж, 6 тойм бичиж, Улсын Дээд шүүхийн мэдээлэл сэтгүүлд хэвлэн нийтийн хүртээл болгосон байна.

Монгол Улсын хуулиуд, Монгол Улсын нэгдэн орсон болон хоёр талын гэрээ хэлэлцээр, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий шүүгчийн захирамж, эрүү, иргэний болон захиргааны хэргийн танхимын болон тус хэлтсээс гаргасан тойм зөвлөмж, шүүн таслах ажлын практик ач холбогдол бүхий хяналтын шатны эрүү, иргэний болон захиргаа, нийт шүүгчдийн хуралдааны тогтоолуудаар Улсын Дээд шүүхийн мэдээллийн “Нэгдсэн сан”-г баяжуулж байна.

Мөн Улсын Их Хурлын тогтоол 87, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 43 дугаар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 32, Засгийн газрын тогтоол 6, Монгол Улсын хууль 125, Үндсэн хуулийн цэцийн тогтоол, дүгнэлт 14 тус бүр хүлээн авч, нэгдсэн санд болон Legalsystem.mn хуулийн мэдээллийн санд тус тус оруулжээ.

Түүнчлэн 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар Монгол Улсын хууль 225 хүлээн авч, нэмэлт өөрчлөлт орсон 159 хууль, зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцогдсон 15 хууль, хүчингүй болсон 19 хуулийн эх хууль болон “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн хувьд тухай бүрт нь ажилбар хийж, нэгдсэн сан дахь хуулиудад өөрчлөлтийг давхар оруулсан байна.

Мөн 1911-2015 онд батлагдан гарсан эрүү, иргэний болон захиргааны материаллаг болон процессын хууль тогтоомжийн цахим санг Үндсэн хууль болон органик хууль 35, материаллаг 16, процессын 12 хуулиар бусад холбогдох эрх зүйн 50 актаар тус тус бүрдүүлж, шүүхтэй холбоотой хууль тогтоомжуудыг архиваас судлах, хуулбарлах, хянах, байршуулах ажлыг гүйцэтгэлээ.

Улсын Дээд шүүхийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол Улсад шүүх байгуулагдсаны 105 жил, Улсын Дээд шүүхийн 90



жилийн ойг угтаж “**Монголын шүүх-I**” ботийг боловсруулан дуусгаж, “**Монголын шүүх-II**” ботийг бичиж хэвлүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.

Мөн тус шүүхийн эрүү, иргэний болон захиргааны хэргийн танхимын тэргүүдэд нарт “**Шүүхийн прецедент**”, “**Гадаад улс орнуудын хяналтын шүүх**”, “**Монгол Улсын шүүхээс сүүлийн 5 жилд хянан шийдвэрлэсэн хэрэг маргаан**” сэдвээр дэлгэрэнгүй гарын авлага бэлдэж, шүүн таслах ажиллагаанд туслалцаа үзүүлжээ.

4. Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

Монгол Улсын Дээд шүүхийн 2015 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус хэлтэс нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланг холбогдох байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх, санал дүгнэлт гаргуулах, төсвийн төлөвлөлт ийг оновчтой зөв тооцон боловсруулах, батлуулах, хуваарилах, батлагдсан төсвийг хууль, тогтоомжийн дагуу зөв зохистой зарцуулах, төсөв санхүү болон бусад холбогдох хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг хангах зэрэг үндсэн чиг үүргийн ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Улсын Дээд шүүхийн 2015 оны төсөв нь Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулиар **3.902.7** төгрөгөөр батлагдсан боловч дээрх хуулинд нэмэлт өөрчлөлт орсноор **3.876.9** төгрөгөөр болж, төсвийг хяналтын шатны шүүхийн хэвийн үйл ажиллагааг хангахад зарцуулсан байна.

Үндэсний Аудитын газарт Улсын Дээд шүүхийн 2014 оны жилийн эцсийн болон 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гарган тайлагнаж, хүргүүлснээс төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, “Улсын Дээд шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан УСНББҮУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн шударга илэрхийлэгдсэн байна” гэж дүгнэн, “**Зөрчилгүй санал дүгнэлт**” өгсөн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Дээд шүүхийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан 2016 оны урсгал төсвийг **8.9** тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсвийг **20.9** тэрбум төгрөг



буюу нийт **29.8** тэрбум төгрөгөөр төлөвлөж, хязгаарын саналыг боловсруулж холбогдох газруудад хүргүүлсэн боловч улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан 2016 оны урсгал төсөв **3.396.2** төгрөгөөр батлагдсан байна.

Батлагдсан төсвийг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.2 дахь заалтад заасны дагуу хуваарийн төсөл боловсруулан Сангийн ямаар хүргүүлж, **Fiscal** програмд оруулж мөн шүүхийн 2015 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг **e-procurement.mn** сайт дээр байршуулж ажиллалаа.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх хэсэгт **“Шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй байлгах, аюулгүй байдлыг хангах стандартад нийцсэн шүүхийн байр, худалдааны танхим болон бусад барилга байгууламж барих засвар хийх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төлөвлөх, зураг төсвийг захиалан боловсруулж гүйцэтгэлийг хангах”** гэж заасны дагуу Улсын Дээд шүүхийн шүүх хуралдааны танхим, 1-4 давхрын коридор, ариун цэврийн өрөөнүүд болон үүдний хэсгийн засварын ажлуудыг **“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”** болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд **55.9** сая төгрөгөөр гүйцэтгүүлж, шүүгч, ажилтнуудын албан тасалгааг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлж, тохь тухтай ажиллах нөхцлийг нэмэгдүүлжээ.



Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1.3-т **“шүүгч, ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрмж, техник хэрэгслээр хангах”**



гэж заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд Төрийн өмчийн хорооноос зохих зөвшөөрөл авснаар **32.1** сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж авч үндсэн хөрөнгөнд бүртгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

Түүнчлэн шүүхийн дулаан дамжуулах шугамын насосд эвдрэл гарсан байсныг засварлан шинээр насос тавьж, авто тээврийн хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг хангах урсгал засвар хийх, эвдрэл гэмтлүүдийг засварлах, даатгал, оношлогоо зэрэг ажилд **30.7** сая төгрөгийг зарцуулсан байна.



Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хяналтын шатны шүүн таслах болон бусад ажлыг таниулах, сурталчлах, хэргийн оролцогч, иргэд, хуулийн этгээдэд түргэн шуурхай мэдээлэл хүргэх, дуу, дүрс фото зургийн хэлбэрээр мэдээлэл түгээх зорилгоор Улсын Дээд шүүхийн цахим хуудсыг шинэчлэх, вирусны програм суулгах зэрэг ажлыг **13.2** сая төгрөгөөр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэхэд хамтран ажиллаж санхүүжүүлээ.

Шүүхийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт **“Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг улсын төсвөөс хариуцна”** гэж заасны дагуу худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж **37.2** сая төгрөгөөр **“Бодь даатгал”** ХХК шалгарснаар гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Түүнчлэн 2015 онд шагнал урамшууллын зардлаас **30** хүнд **1.3** сая төгрөг, буцалтгүй тусламжаар **37** хүнд **6.7** сая төгрөг, “Төрийн албаны тухай хууль”-д заасны дагуу төрсөн нутагтаа амрах унааны зардлаас **2** хүнд **86.6** мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлаас **4** хүний үлдэгдэл тооцоо болох **271.2** сая төгрөгийг тус тус зарцуулснаар шүүгч, ажилтнуудын нийгмийн халамжид дэмжлэг үзүүлсэн байна.



Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдах **“Payroll”** цалингийн програмыг төлөвлөсөн хугацаандаа хэрэглээнд оруулж, ашиглаж эхэлсэн бөгөөд цалин бодох ажиллагааг хөнгөвчилж, мэдээллийг нийгэд нэгэн зэрэг өгөх боломжтой боллоо.

Улсын Дээд шүүхийн **2014** оны жилийн эцсийн тооллого, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрүүдийг үндэслэн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан **28.2** сая төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг, мөн 2015 оны эхний хагас жилийн байдлаар **49.2** сая төгрөгийн тоног төхөөрөмжийг актлах, **2.8** сая төгрөгийн үндсэн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд шилжүүлэх тус тус хүсэлтийг Төрийн өмчийн хороонд хүргүүлснээр тус хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан **“Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”**-ын 5.7 дахь заалтыг үндэслэн **77.7** сая төгрөгийн тоног төхөөрөмж, хөрөнгийг актлах, шилжүүлэхийг зөвшөөрсөн болно.

Дээрх журмын дагуу Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 85 тоот тушаалаар акталсан эд хөрөнгийг устгах комисс байгуулагдаж, акталсан хөрөнгийг зохих хууль тогтоомжид зааснаар данснаас хасч, шилжүүлэх, бүртгэхтэй холбогдсон тайлан мэдээг ТӨХ-нд 5/1695 тоот албан бичгээр хариу хүргүүлжээ.

Мөн **“Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”**-ийн программ хангамжид Улсын Дээд шүүхийн 2014 оны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдэл, холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь багтаан оруулжээ.

Төрийн өмчийн хорооноос жил бүр байгууллага болгонтой **“Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх журам”**-ын дагуу гэрээний биелэлтийг дүгнэж, 2015 оны байдлаар хөрөнгийн хөдөлгөөн, хадгалалт хамгаалалтын талаар Улсын Дээд шүүхийн Тамгын газар нь **“Бүрэн хангалттай” 97** буюу **“А”** үнэлгээ авчээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасны дагуу Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2015 оны 83, 161 дүгээр тушаалуудаар үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого хийх комисс байгуулагдан хагас, бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг хийж, нэгдсэн дүнг тайлагналаа.

Улсын Дээд шүүхийн хөрөнгийн тооллогоор;

- автомашин техник хэрэгсэл 13 ширхэг, нийт 984,972,778 төгрөг,
- барилга 454,220,775 төгрөг,
- тавилга, эд хогшил 418,174,551.83 төгрөг,



- тоног төхөөрөмж 312,336,703.20 төгрөг,
- гадна инженерийн шугам болон нийтийн эзэмшлийн талбайд 182,818,170 төгрөг,
- тавилга, багаж хэрэгсэл 63,794,400 төгрөг
- бусад 33,588,955 төгрөг,
- номын санд 2,838,618.10 төгрөг /үнэ бүхий номын фондтой/, нийт 2,452,744,951,13 төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгө тоологдлоо.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд www.shilendans.dbv.mn болон Улсын Дээд шүүхийн www.supremecourt.mn сайт дахь төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бүтэн, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, цалингаас бусад 5 сая төгрөгөөс хэтэрсэн зардал зэрэг холбогдох шаардлагатай мэдээ, мэдээллүүдийг цаг тухай бүрт нь хуулийн хугацаанд оруулан ажиллаж байна.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн хэвийн ажиллагааг хангахад зарцуулсан бөгөөд мэдээлэл сурталчилгаа, сургалт семинар зохион байгуулах, гадаад, дотоодын айлчлал, зочин хүлээж авах, шүүхийн ахмадуудыг хүлээн авах, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг ажлуудад 171.2 сая төгрөгийн зардал гаргаж, 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг жилийн төсвийн хэмжээнд дэмжин ажиллажээ.

5. Шүүхийн зохион байгуулалтын чиглэлээр:

Тус хэлтэс нь шүүх хуралдааны бэлтгэл ажлыг хангах, танхимын тэргүүн, шүүгч нарт хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол, тэмдэглэл, шүүгчийн захирамжийн төсөл боловсруулж танилцуулах, ёсчлуулах, тэдгээрийг www.shuukh.mn болон www.supremecourt.mn цахим хуудсанд байршуулах зэрэг ажлыг зохих хууль тогтоомжид заасны дагуу хийж гүйцэтгэжээ.

Мөн танхимын тэргүүний туслах, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлын зохион байгуулалт, хэргийн хөдөлгөөний стандарт, албан хэрэг хөтлөлт, цахим санд шүүхийн шийдвэр нийтлэх журам хэрхэн хэрэгжиж байгаатай үзэж танилцан, хяналт тавьж ажиллаж байна.

Тахарын албаны тухай хууль болон Хууль зүйн сайд, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2014 оны А/96, 90 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-ын дагуу Тахарын албаны



ажилтан Улсын Дээд шүүхийн шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангаж, шүүх хуралдааны журам сахиулан ажиллах хугацаандаа /2015 оны 1 дүгээр сарын 1-нээс 2015 оны 11 дүгээр сарын 27/ Эрүүгийн хяналтын шатны 332 шүүх хуралдааны 271, Иргэний 1229 шүүх хуралдааны 1058, Захиргааны 465 шүүх хуралдааны 361 хуралд /нийт 1690/ тус тус дэг журам сахиулан, 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 29-ний өдрүүдэд Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн урилгаар Монгол улсад айлчилсан БНЭУ-ын “СИТИ МОНТЕССОРИ” сургуулийн үүсгэн байгуулагч, дэлхийн Ерөнхий шүүгч нарын чуулга уулзалтыг үндэслэгч бөгөөд зохион байгуулагч, доктор **Жагдиш Ганди** тэргүүтэй төлөөлөгчдийн аюулгүй байдлыг ханган биечилсэн хамгаалалтыг тус тус хийж гүйцэтгэжээ.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтад “**шүүхийн цахим болон бусад хэлбэрийн мэдээллийн сан бүрдүүлэх**” гэж заасны дагуу 2015 онд хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн эрүү, иргэний болон захиргааны хэргийн тогтоолыг **Shuukh.mn** сайтад байршуулжээ.

Мөн 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авсан Улсын Дээд шүүхийн шинэ вэб сайтад “**хяналтын шатны шүүх хуралдааны зар, тойм**”-ыг тус тус тогтмол байршуулж байна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан чиг үүргийн дагуу /шүүгчийн туслахууд/ шүүгчид хуваарилагдсан хэрэг, маргааны талаарх бичиг баримтын бүрдлийг судалж, хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгчээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, шаардлагатай хууль тогтоомжийн талаар мэдээлэл бэлтгэх, хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах зэрэг ажлуудыг гүйцэтгэжээ.

Тайлангийн хугацаанд шүүгчийн удирдлага дор эрүү, иргэн, захиргааны хэргийн нийт 1884 тогтоол, захирамжийн, 281 албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтэд төсөл боловсруулан, шүүгчид танилцуулан, ёсчлуулсан байна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан чиг үүргийн дагуу /шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар/ шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж эрүү, иргэн, захиргааны нийт 2699 шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөж, шүүх хуралдааны дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулж, шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчдод хуульд



заасан хугацаанд танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэргийн материалд хавсаргажээ.

6. Шүүхийн хэвлэл мэдээллийн чиглэлээр:

Телевизийн нэвтрүүлгийн хувьд:

Улсын Дээд шүүхийн шүүгч асан, хуульч А.Доржготов 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдөр МҮОНТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт оролцож “Өв залгамжлал гэрээслэл”-ийн сэдвээр;

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь 2015 оны 6 дугаар сарын 10-ны өдөр МҮОНТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт оролцож “Гүтгэх, доромжлох гэмт хэргийн тухай асуудал” сэдвээр;

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч Г.Буяннэмэх 2015 оны 6 дугаар сарын 17-ны өдөр МҮОНТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт оролцож “Залилан мэхлэх гэмт хэрэг” сэдвээр;

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Д.Баатархүү 2015 оны 8 дугаар сарын 19-ний өдөр МҮОНТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт оролцож “Газрын маргаан” сэдвээр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Д.Батбаатар 2015 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр МҮОНТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт оролцож “Эд хөрөнгийн улсын бүртгэлийн маргаан”-ы сэдвээр,

Улсын Дээд шүүхийн шүүгч асан, хуульч А.Доржготов 2015 оны 10 дугаар сарын 21-ний өдөр МҮОНТ-ийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт оролцож “Гэр бүлийн дундын өмч”-ийн сэдвээр,

Улсын Дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн “Eagle” телевизийн “Иргэний мэдээ” нэвтрүүлгийн 2015 оны 11 дүгээр сарын 5-ний өдрийн дугаарт оролцон “Өршөөлийн хуулийг шүүх хэрхэн хэрэгжүүлж буй талаар” сэдвээр ярилцлага тус тус өгчээ.

Мөн NBS телевизтэй хамтран 2015 оны 2 дугаар сарын 27-ны өдөр захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэх болон Захиргааны ерөнхий хуультай холбоотой нэвтрүүлгийг,

Улсын Дээд шүүхийн шүүгч Ч.Хосбаяр 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдөр МҮОНТ-ийн “Нээлттэй хэлэлцүүлэг”, “Цагаан тахлын хар мөр” нэвтрүүлэгийг бэлтгэжээ.

Түүнлэн 2015 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр “Газрын маргаан” сэдвээр, 2015 оны 8 дугаар сарын 26-ны өдөр “Цахим гэмт хэрэг” сэдвээр, 2015 оны 9



дүгээр сарын 16-ны өдөр “Эд хөрөнгийн улсын бүртгэлийн маргаан” сэдвээр, 2015 оны 10 дугаар сард “Гэр бүлийн маргаан” сэдвээр зохиомжит нэвтрүүлэгт хийсэн байна.

Радиоогийн нэвтрүүлгийн хувьд:

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** 2015 оны 2 дугаар сарын 28-ны өдөр МҮОНР-гийн “Тод журам” нэвтрүүлэгт оролцож, “Шүүхээс хүний эрхийг хамгаалах” сэдвээр,

Улсын Дээд шүүхийн шүүгч **Д.Эрдэнэсүвд** 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр МҮОНР-гийн “Соёмбо” шууд нэвтрүүлэгт оролцож, “Эвлэрүүлэн зуучлал”-ын сэдвээр тус тус ярилцлага өгчээ.

Захиргааны ерөнхий хуулийг сурталчлах хүрээнд хуульч **Д.Сүнжид** 2015 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Монголын Үндэсний олон нийтийн радиоогийн хууль эрх зүйн “Соёмбо” нэвтрүүлэгт “Захиргааны ерөнхий хуулийн үр нөлөө, ач холбогдол” сэдвээр ярилцлага өгснийг тус хэлтэс зохион байгууллаа.

Сонин, сайтын нийтлэлийн хувьд:

Шүүхийн талаар бодиг ойлголт олон нийтэд хүргэх үүднээс шүүхийн шинэчлэл болон шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэртэй холбоотой давхардсан тоогоор нийт **41** нийтлэл, ярилцлага, сурвалжлагыг өөрсдөө бэлтгэх буюу сэтгүүлчдээр бэлдүүлэн сонин, сайгад нийтлүүлжээ.

Сэтгүүлчдэд зориулсан сургалтын хувьд:

Хууль эрх зүйн чиглэлээр дагнан мэргэшиж буй сэтгүүлчдэд зориулан уламжлал болгон явуулдаг “Шүүхийг сурвалжлах нь” цуврал сургалтыг 2015 оны 5 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулж, хөтөлбөрт тусгасны дагуу нийт **21** сэтгүүлч хамрагдлаа. Тус сургалтад Улсын Дээд шүүхийн шүүгч **П.Золзаяа** “Гэр бүлийн маргаан” сэдвээр, Улсын Дээд шүүхийн шүүгч **Б.Ундрах** “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр, Улсын Дээд шүүхийн шүүгч **Д.Мөнхтуяа** “Өрсөлдөөний эрх зүй” сэдвээр, Улсын Дээд шүүхийн шүүгч **Л.Атарцэцэг** “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр, Улсын Дээд шүүхийн шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** “Авилга, албан тушаалын гэмт хэрэг” сэдвээр, Улсын Дээд шүүхийн шүүгч **Б.Цогт** “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа” сэдвээр хичээл заасан байна.

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимаас 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдөр хэвлэлийн бага хурал зохион байгууллаа.



Уг хуралд Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Т.Уранцэцэг Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан “Өршөөл үзүүлэх тухай хууль”-ийг шүүхээс хэрэгжүүлсэн байдлын талаар, шүүгч Д.Ганзориг тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасны дагуу ял шийтгэлээс өршөөн хэлтрүүлсэн талаар, шүүгч Б.Батцэрэн тус хуулийн 5 дугаар зүйлийн дагуу ялаас өршөөн хассан, 7 дугаар зүйлийн дагуу эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон талаар мэдээлэл хийлгээ.

Нийтлэл, нэвтрүүлгийн уралдааны хувьд:

Улсын Дээд шүүхээс “Шүүх ба хүний эрх” сэдэвт нийтлэл нэвтрүүлгийн уралдааныг 2014 оны 11 дүгээр сарын 01-нээс 2015 оны 3 дугаар сарын 01-ний хооронд зарлаж, уралдаанд ирсэн бүтээлүүдээс шалгуур үзүүлэлтийг хангасан 16 бүтээлийг Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүн, шүүгчид, Тамгын газрын даргын бүрэлдэхүүнтэй баг дүгнэн, телевиз радио, сонин, сайт гэсэн төрлүүдээр тус бүр 3 байрыг шалгаруулж, шагналыг 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр гардуулан өгчээ.




7. Ерөнхий шүүгчийн ажлын алба.

Тус алба нь тайлангийн хугацаанд нийт **98** албан бичиг, **42** өргөдөл, гомдол хүлээн авч, хуулийн хугацаанд нь хариу өгчээ.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн **42**, иргэний **157**, захиргааны **48**, нийт **247** хэрэг хүлээн авч, Ерөнхий шүүгчид танилцуулж, хариу өгсөн байна.

Өмнөх онтой харьцуулбал:



Ажлын албаны дарга, бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч **82** иргэнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гарат болон хөдөө орон нутгаас ирсэн иргэдийг тухайн өдөрт нь хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдний санал, хүсэлтийг Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгчээ.

Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдлын дагуу эрүү, иргэний болон захиргааны хэргийг хянах явцад шүүх, шүүгчдийн болон захиргааны ажилтнуудын гаргасан алдаа, зөрчилд анхаарах асуудлаар тусгайлан бүртгэл хөтөлж, шүүгч, ажилтанд энэ талаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажиллажээ.

Улсын Дээд шүүхэд 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **43** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч нийтдээ **35** үнэмлэх олгосноос 27 үнэмлэх шинээр, 8 үнэмлэх нөхөн олгожээ.



8. Шүүхийн Гадаад арга хэмжээний чиглэлээр:

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжсөөр байна. Тухайлбал:

- Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** ОХУ-ын Санкт Петербург хотноо 2015 оны 5 дугаар сарын 24-30-ны өдрүүдэд зохион байгуулсан “**Олон Улсын эрх зүйн форум**”-д

- шүүгч **Л.Атарцэцэг, Б.Бат-Эрдэнэ, П.Золзаяа**, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга **Д.Отгонбаатар** нар БНСУ-ын Дээд шүүхийн Үндэсний шүүхийн захиргаанаас 2015 оны 7 дугаар сарын 19-30-ны өдрүүдэд зохион байгуулсан “**Оюуны өмчийн эрх зүй**” сэдэвт;

- шүүгч **Д.Мөнхтуяа**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар БНЭУ-ийн Лакноу хотноо 2015 оны 10 дугаар сарын 05-15-ны өдрүүдэд зохион байгуулсан “**Дэлхийн Ерөнхий шүүгч нарын 16 дугаар бага хурал**” сэдэвт;

- Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Б.Ундрах** нар Японы олон улсын хамтын ажиллагааны “Жайка” байгууллагаас зохион байгуулсан Эвлэрүүлэн зуучлал ба сайн засаглал төслийн хүрээнд 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 11 дүгээр сарын 13-ны өдөр хүртэл Япон улсын Токио хотноо зохион байгуулсан “**Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл**” сэдэвт;

- Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Т.Уранцэцэг**, шүүгч **Ч.Хосбаяр** нар Нидерландын Вант Улсын Гаага хотноо 2015 оны 11 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “**Олон Улсын Эрүүгийн шүүх (ОУЭШ)-ийн Ромын Дүрэмд оролцогч улсуудын Ассамблейн 14 дүгээр чуулган**” сэдэвт чуулга уулзалт, Олон Улсын бага хурал, сургалтад оролцжээ.

Гадаад айлчлалын хүрээнд:

Испанийн Вант Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ноён **Карлос Д.Серраногийн** урилгаар Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Зориг**, Тамгын Газрын дарга **Ж.Наранпүрэв**, Ерөнхий шүүгчийн туслах, ахлах референт **Б.Бямбабаатар** нар тус Улсын Мадрид хотноо 2015 оны 06 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд албан ёсны ажлын айлчлал хийх ажлыг зохион байгуулжээ.



Уулзалтын үеэр хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх, бэхжүүлэх, харилцан туршлага, мэдээлэл солилцох, тэр дундаа Монгол Улсын шүүхийн шүүгч нарыг Испанийн Вант Улсын шүүхэд мэргэшүүлэн сургах талаар харилцан санал солилцож, тодорхой шийдэлд хүрсэн байна.

Түүнчлэн Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зоригийн урилгаар Дэлхийн Ерөнхий шүүгч нарын чуулга уулзалтыг зохион байгуулагч доктор **Жагадиш Ганди** тэргүүтэй тэргүүтэй төлөөлөгчдийг 2015 оны 5 дугаар сарын 25-30 өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлалын;

- Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын урилгаар БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн Захиргаа удирдлага, Хангамжийн хэлтсийн дарга **Ван Шаонан** тэргүүтэй төлөөлөгчид 2015 оны 9 дүгээр сарын 10-13-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлалын;

- Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын урилгаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Дээд шүүхийн дарга **Ноён Хү Ифэн** тэргүүтэй төлөөлөгчдийн 2015 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 2-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлалын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулжээ.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:

Улсын Дээд шүүхийн шүүгч **Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдөр АНУ-ын Элчин сайдын яамны Улс төрийн хэлтсийн дарга ноён **Брайн Күүнз**, АНУ-ын Элчин сайдын яамны Улс төрийн хэлтсийн мэргэжилтэн **М.Нюминцэцэг** нарыг хүлээн авч уулзаж хоёр улсын хоорондын хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийн талаар харилцан санал бодлоо солилцсон байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **П.Соёл-Эрдэнэ**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар 2015 оны 5 дугаар сарын 08-ны өдөр ЖАЙКА Япон Улсын хамтын ажиллагааны газраас хэрэгжүүлэх гэж буй “**Монгол Улсын шударга бус өрсөлдөөний хориглох орчин нөхцөлийг чадваржуулах**” төслийн хүрээнд Япон Улсын Шударга бус өрсөлдөөний газрын төлөөлөгчид болон албан бусад хүмүүсийг хүлээн авч уулзжээ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч **Ц.Зориг** 2015 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Ханнс-Зайделийн сангийн тэргүүн профессор. **Урсула Мэнгле**, Бавари муж улсын Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн сайд профессор, доктор



Винфрид Баусбак, тус сангийн Монгол Улс дахь төслийн удирдагч Доктор (Sc.D), профессор. **Ц.Сарантуяа** болон холбогдох бусад төлөөлөгч нарыг хүлээн авч уулзсан байна.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** 2015 оны 7 дугаар сарын 07-ны өдөр АНУ-ын Элчин сайдын яамны Улс төрийн хэлтсийн дарга ноён **Брайн Күүнзтэй** Монгол Улс болоод АНУ-ын засгийн газар хоорондын хууль зүйн салбарт, тэр дундаа хар тамхи мансууруулах бодистой тэмцэх, энэ талаар хамтран ажиллах, шүүгч нарыг мэргэшүүлэх, сургах, хамтын ажиллагааны гэрээний төсөлд оруулах санал, зөвлөмжийн талаар харилцан санал бодлоо солилцсон байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** 2015 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын урилгаар Монгол Улсад ажлын айлчлал хийсэн Найрамдах Польш Улсын шүүхийн Үндэсний зөвлөлийн дэд дарга, Варшавын цэргийн тойргийн шүүхийн шүүгч, хурандаа ноён **Пиотр Рачковски** тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж хоёр улсын шүүхийн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан туршлага судалжээ.

Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны бусад чиг үүргийн хүрээнд:

Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** 2015 оны 6 дугаар сарын 02-04- ны өдрүүдэд Авилгатай тэмцэх газар болон Дэлхийн банкны Монгол дахь салбартай хамтран зохион байгуулсан “**Баримт нотолгооны матрикс болон бусад мөрдөн шалгах ажиллагааны арга хэрэгслийг ашиглаж, эрх зүйн туслалцааны хүсэлтийг боловсруулах**” сэдэвт сургалтад хамрагдлаа.

Гадаад харилцааны асуудлаар хийх уулзалт, зөвлөгөөний бэлтгэлийг урьдчилан хангаж, удирдлагыг тухайн асуудлаарх шаардлагатай мэдээллээр ханган Ерөнхий шүүгч болон шүүгчдийг гадаадын зочид, төлөөлөгчидтэй уулзах үед орчуулагчаар ажилласан байна.

Гадаадын байгууллага, иргэдээс ирсэн албан бичиг, захидал, зохиол, бусад материалыг монгол хэлнээ хөрвүүлэн, Ерөнхий шүүгчид танилцуулсан, Ерөнхий шүүгчээс гадаадын байгууллага, иргэдэд явуулж буй албан бичиг, захидал, урилгыг англи хэл дээр хөрвүүлжээ.



Гадаад улс орны шүүхийн үйл ажиллагааны туршлага судалж, манай улс оронд нэвтрүүлж болох зүйлийг хэрэгжүүлэх талаар анхаарал хандуулан ажиллаж байна.

9. Дотоод аудитын алба:

Дотоод аудитын алба нь 2015 онд байгууллагад оршин буй алдаа зөрчлийг тайлагнахаас илүүтэйгээр байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, гарч болох алдаанаас сэргийлэх, дотоод хяналтын сул талыг сайжруулахад чиглэн ажиллаа.

Шинээр байгуулагдсан уг алба нь ОУ-ын стандартын хүрээнд дотоод бүтэц чиг үүргийг боловсронгуй болгон, төлөвшүүлэх улмаар байгууллагын үйл ажиллагааны онцлог тохирох аудитын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Энэхүү зорилтыг хангахын тулд Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Ерөнхий шүүгчийн баталсан **“Эрсдэлд суурилсан Дотоод аудитын төлөвлөгөө”** боловсруулан батлуулж, уг төлөвлөгөөний дагуу ажиллаж төлөвлөгдсөн ажлуудыг заасан хугацаанд хэрэгжүүлсэн байна.

Үндэсний Аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитын бэлтгэл, шилэн дансны хэрэгжилт, төлөвлөгөөт болон удирдлагын шийдвэрээр тусгайлсан аудитыг хэрэгжүүлсэн. Дотоод аудитаар удирдлагаас хэрэгжүүлж байгаа дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлыг шалгаж үнэлэн, байгууллагын үйл ажиллагаа нь холбогдох бодлого, горим, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхийг авч үзсэн байна. Мөн эрсдлийн удирдлага ба засаглалын бусад асуудлаар зөвлөмж өгч ажиллажээ.

Тухайлсан дотоод аудитын ажлыг мэргэжлийн стандартын дагуу цаг хугацаанд нь дуусгаж, тайлагнаж ажилласан. Удирдлагад өгсөн зөвлөмж хэрэгжсэн эсэх, үр нөлөөтэй хариу арга хэмжээ авсан эсэх талаар удирдлагад тогтмол тайлагнасан. Аудитын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу сар тутам төлөвлөж ажилласан байна. Үүнд:

2015 оны Санхүүгийн тайланд урьдчилсан аудит хийж, дутуу баримтуудад бүрдүүлэлт хийлгэх зөвлөмж өгч ажиллалаа. ҮАГ-аас Улсын Дээд шүүхийн 2014 оны санхүүгийн жилийн эцсийн тайланд **“Зөрчилгүй”** дүгнэлт гарсан байна. ҮАГ-тай аудит хийхтэй холбоотойгоор мэдээлэл солилцох, туршлага судлах хэлбэрээр хамтран ажиллажээ.

Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор уг хуулийн 8 дугаар зүйлийн 2-т заасны дагуу дотоод хяналтыг зохион байгуулж, 2015 оны



батлагдсан төсөв, 1,2,3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг шилэн дансанд байршуулж жигдрүүлсэнээр <http://shilendans.gov.mn/> сайтад мэдээлэл хуулийн хугацаанд тогтмол тавигдаж хэвшсэн байна.

Түүнчлэн шүүгч, ажилтнуудын цалин олголт, нийгмийн даатгал, татварын тооцролол, цагийн бүртгэлийн системийн хяналтад аудит хийх шалгуур эрх зүйн акт, мэдээлэл цуглуулах, төлөвлөх төлөвлөгөөний дагуу аудит хийж дүнг нэгтгэн Ерөнхий шүүгч, Тамгын даргад танилцуулахад бэлэн болоод байна.

Сангийн яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу 2015 оны бараа материалын хөдөлгөөн, зарцуулалт, тайлагналд гүйцэтгэлийн аудит хийж, удирдлагад танилцуулж сангийн яаманд хүргүүлжээ.

Мөн УИХ-ын Тамгын газартай хамтран “Нээлттэй эх”-ийн программ хангамжийг өөрийн байгууллагад хэрэгжүүлэх талаар судалгаа хийж, сургалт зохион байгуулсан байна.

Улсын Дээд шүүхийн захиргааны ажилтнуудын зан үйлийн болон үйл ажиллагааны стандарт боловсруулж тамгын даргаар батлуулахаар хүргүүлээд байна.

Эрүүгийн хэргийн танхим, Иргэний хэргийн танхим, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах болон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажил үүргээ гүйцэтгэж буй байдалд шүүхийн зохион байгуулалтын хэлтэстэй хамтран нийцлийн аудитыг хийж үнэлэлт дүгнэлт гаргажээ.

Байгууллагын үйл ажиллагаанд нийцсэн дотоод аудит хийх аргачилал боловсруулан эрсдлийн бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын 2015-2017 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах төслийг бэлтгэсэн байна.

Шүүхийн захиргааны болон үйлчилгээний ажилтнуудын 2015 оны хагас, бүтэн жилийн үр дүнгийн гэрээний төсөл, биелэлтэнд нийцлийн аудит хийж ажлын тайланг Тамгын газрын даргад хүргүүлж, танилцуулжээ.

Үйл ажиллагааны эрсдлийг бууруулах ажлын хүрээнд байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулсан бөгөөд Чингэлтэй дүүргийн ГХХэлтэстэй хамтран шүүгч, ажилтнуудад “Гамшгаас хамгаах сургалт”-ыг зохион байгуулсан байна.



10. Шүүхийн сургалт, семинарын чиглэлээр:

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнууд 2015 онд дараах сургалт, семинарыг зохион байгуулж, оролцлоо. Үүнд:

Эрүүгийн хэргийн танхим

Танхимын тэргүүн **Т.Уранцэцэг**, шүүгч **Б.Батцэрэн**, **Б.Бат-Эрдэнэ**, **Д.Ганзориг**, **Б.Цогт**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар 2015 оны 2 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч нарт зориулсан **“Монгол Улс дахь шүүн таслах ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”** сэдэвт сургалт-уулзалтын хүрээнд **“Эрүүгийн шүүн таслах ажиллагааны алдаа зөрчлийн тойм” /шүүхийн шат/**, **“Эрүүгийн шүүн таслах ажиллагааны алдаа зөрчлийн тойм” /шүүхийн өмнөх шат/**, **“Шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй, түүнд тавигдах шаардлага”** сэдвээр тус тус хичээл заасан байна.

Танхимын тэргүүн **Т.Уранцэцэг**, шүүгч **Б.Батцэрэн**, **Б.Бат-Эрдэнэ**, **Д.Ганзориг**, **Ч.Хосбаяр**, **Б.Цогт**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар 2015 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нартай **“Шүүн таслах ажиллагаа, хууль хэрэглэх, тайлбарлах, шүүхээс гаргах шийдвэрийн талаарх практик”** сэдэвт уулзалт-ярилцлагыг тус тус зохион байгуулжээ.

Шүүгч **Б.Батцэрэн**, **Б.Бат-Эрдэнэ**, **Б.Цогт**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар 2015 оны 11 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан **“Эрүүгийн эрх зүйн сургалт”**-ын хүрээнд орон нутгийн шүүхүүдэд ажиллан бүсчилсэн сургалтыг удирдан явуулсан байна.

Шүүгч **Б.Бат-Эрдэнэ**, **Б.Батцэрэн**, **Д.Ганзориг**, **Ч.Хосбаяр**, **Б.Цогт**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар 2015 оны 4 дүгээр сард УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, МУИС-ийн Хууль зүйн сургуультай хамтран зохион байгуулсан **“Үндсэн хууль тайлбарлах онол арга зүй”** сэдэвт;

-шүүгч **Б.Бат-Эрдэнэ** 2015 оны 5 дугаар сард УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангай хамтран зохион байгуулсан **“Эрх зүйт төр-Эрхэм зорилго”** сэдэвт, 2015 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Ханнс-Зайделийн сангаас зохион байгуулсан **“Монгол Улс дахь эрүүгийн эрх зүйн шинэчлэл, өнөөгийн байдал, хөгжлийн хандлага”** сэдэвт олон улсын онол, практикийн бага хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлжээ.



Шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** 2015 оны 4 сарын 10-ны өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөл, Эрх зүйн боловсрол академиас хамтран зохион байгуулсан **“Эрүүгийн эрх зүйн-сургагч багш”** сэдэвт уулзалт-ярилцлагад;

Шүүгч **Д.Ганзориг** 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулсан **“Эрүү шүүлт болон хохирогчийн эрхийн өнөөгийн төлөв байдал, цаашид анхаарах асуудал”** сэдэвт уулзалтад тус тус оролцжээ.

Иргэний хэргийн танхим

Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Ц.Амарсайхан**, **Б.Ундрах**, **Г.Цагаанцоож**, **Д.Цолмон**, **Х.Эрдэнэсүвд** нар 2015 оны 02 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч нарт зориулсан **“Монгол Улс дахь шүүн таслах ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”** сэдэвт сургалт-уулзалтын хүрээнд **“2014 оны шүүн таслах ажиллагаа, алдаа зөрчлийн тойм, анхаарах бусад асуудал”** **“Гэм хор учруулснаас үүсэх үүрэг, хариуцлага хүлээх үндэслэл”**, **“Арбитрын ажиллагаа дахь шүүхийн оролцоо”**, **“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчийн дүгнэлтийн талаар анхаарах зарим асуудал”** сэдвээр тус тус хичээл заасан байна.

Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Ц.Амарсайхан**, **Б.Ундрах**, **Г.Цагаанцоож**, **П.Золзаяа**, **Д.Цолмон**, **Х.Эрдэнэсүвд** нар 2015 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нартай **“Шүүн таслах ажиллагаа, хууль хэрэглэх, тайлбарлах, шүүхээс гаргах шийдвэрийн талаарх практик”** сэдэвт уулзалт-ярилцлагыг тус тус зохион байгуулжээ.

Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Ц.Амарсайхан**, **Г.Алтанчимэг**, **П.Золзаяа**, **Б.Ундрах**, **Г.Цагаанцоож**, **Д.Цолмон**, **Х.Эрдэнэсүвд** нар 2015 оны 6 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд Улсын Дээд шүүх болон Шүүхийн Ерөнхий зөвлөл, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн **“Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах”** төслөөс хамтран зохион байгуулсан **“Нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал”** сэдэвт сургалтад хамрагджээ.

Шүүгч **Ц.Амарсайхан**:

- 2015 оны 04-06 саруудад **“Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо”** сэдвээр;



- 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгч, захиргааны албан хаагч нарт зориулж **“Ажил гүйцэтгэх гэрээ ба гэрээний эрх зүй”** сэдвээр;

- 2015 оны 09-11 дүгээр саруудад Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчид **“Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоо”** сэдвээр;

- 2015 оны 11 дүгээр сарын 02-06-ны өдрүүдэд Нийслэл дэх иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт **“Нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал”** сэдвээр;

- 2015 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн Тамгын газраас зохион байгуулсан сургалтанд **“Хууль зүйн бичиг баримт боловсруулах хуульчийн ур чадвар”, “Хуульчийн мэргэжлийн ур чадвар”** сэдвээр тус тус хичээл заажээ.

Шүүгч **П.Золзаяа**:

- 2015 оны 5 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд **“Шүүхийг сурвалжлах нь”** сэтгүүлчдэд зориулсан цуврал сургалтад **“Гэр бүлийн маргаан”** сэдвээр;

- 2015 оны 10 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд Нийслэл дэх иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарт **“Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй: нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шийдвэр боловсруулах арга зүй”** сэдвээр;

- 2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр **“Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”** сэдвээр тус тус хичээл заажээ.

Шүүгч **Б.Ундрах** 2015 оны 5 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд **“Шүүхийг сурвалжлах нь”** сэтгүүлчдэд зориулсан цуврал сургалтад **“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа”** сэдвээр хичээл заажээ.

Захиргааны хэргийн танхим

Танхимын тэргүүн **С.Батсуурь**, шүүгч **Л.Атарцэцэг**, **Х.Батсүрэн**, **О.Зандраа**, **Д.Мөнхтуяа**, **Ц.Сумьяа**, **Ч.Тунгалаг**, нар 2015 оны 02 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч нарт зориулсан **“Монгол Улс дахь шүүн таслах ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага”** сэдэвт сургалт-уулзалтын хүрээнд **“Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь алдаа зөрчлийн тойм”**, **“Тогтоол, шүүгчийн захирамжтай холбоотой анхаарах зарим асуудал”**, **“Нотлох**



баримтыг цуглуулах, үнэлэх зарим асуудал”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хууль хэрэглэх, тайлбарлах асуудал” сэдвээр тус тус хичээл заасан байна.

Танхимын тэргүүн **С.Батсуурь**, шүүгч **Л.Атарцэцэг**, **Х.Батсүрэн**, **О.Зандраа**, **Д.Мөнхтуяа**, **Ц.Сумьяа**, **П.Соёл-Эрдэнэ**, **Ч.Тунгалаг** нар 2015 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нартай “**Шүүн таслах ажиллагаа, хууль хэрэглэх, тайлбарлах, шүүхээс гаргах шийдвэрийн талаарх практик**” сэдэвт уулзалт-ярилцлагыг тус тус зохион байгуулжээ.

Шүүгч **Л.Атарцэцэг**, **О.Зандраа**, **Ц.Сумъяа**, **Ч.Тунгалаг** нар 2015 оны 5 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Шүүхийн ерөнхий зөвлөл, Ханнс-Зайделийн сангаас хамтран зохион байгуулсан “**Захиргааны ерөнхий хуулийн зарчим**” шүүгч багш нарын сургалтад хамрагджээ.

Танхимын тэргүүн **М.Батсуурь**:

- 2015 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Захиргааны хэргийн шинэ шүүгч нарт “**Захиргааны хэргийн шүүхээс хууль хэрэглэх асуудал**” сэдвээр;
- 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр “**Үндсэн хууль тайлбарлах онол, арга зүй**” сэдвээр;
- 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан Шүүхийн Тамгын газрын дарга нарт зориулсан сургалтад “Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал” сэдвээр;
- 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Ханнс-Зайделын сангаас зохион байгуулсан Засаг даргын Тамгын газрын хуульчдад зориулсан сургалтад “Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал” сэдвээр;
- **М.Батсуурь** 2015 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “**Шүүхийн мэргэшсэн шүүгч**” сургалтанд “**Захиргааны хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог**” сэдвээр;
- 2015 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан “**Анхан шатны шүүхийн шүүгчийн сургалт**”-д “**Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал, хууль хэрэглээ**” сэдвээр тус тус хичээл зааж, илтгэл хэлэлцүүлжээ.

2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “**Үндсэн хууль тайлбарлах онол, арга зүй**” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд оролцсон байна.

Шүүгч **Л.Атарцэцэг**:



- 2015 оны 5 дугаар сарын 23-ны өдөр **“Шүүхийг сурвалжлах нь”** сэтгүүлчдэд зориулсан цуврал сургалтад **“Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”** сэдвээр;
- 2015 оны 5 дугаар сарын 22-ны өдөр ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангаас зохион байгуулсан **“Эрх зүйт төр-эрхэм зорилго”** сэдвээр хичээл зааж, олон улсын онол-практикийн бага хуралд оролцсон байна.

Шүүгч Х.Батсүрэн:

- 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Татварын ерөнхий газраас зохион байгуулсан **“Аймаг, нийслэл, дүүргийн Татварын хэлтсийн хуульч, магадлагчдын сургалт”**-нд **“Нотлох баримт цуглуулах, үнэлэх зарим асуудал”** сэдвээр;
- 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан **“Анхан шатны шүүхийн шүүгчийн сургалт”**-д **“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зарчим, онцлог”** сэдвээр тус тус хичээл заажээ.

Шүүгч О.Зандраа:

- 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр **“Үндсэн хууль тайлбарлах онол, арга зүй”** эрдэм шинжилгээний бага хуралд оролцжээ.

Шүүгч Д.Мөнхтуяа:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажилчдад **“Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбогдох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог”** сэдвээр;
- 2015 оны 5 дугаар сарын 23-ны өдөр **“Шүүхийг сурвалжлах нь”** сэтгүүлчдэд зориулсан цуврал сургалтад **“Өрсөлдөөний эрх зүй”** сэдвээр тус тус хичээл заажээ.
- 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр **“Үндсэн хууль тайлбарлах онол, арга зүй”** сэдэвт;
- 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдөр ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан хамтран Төрийн ордонд **“Эрх зүйт төр-эрхэм зорилго”** сэдэвт олон улсын онол-практикийн бага хуралд тус тус оролцсон байна.
- 2015 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хууль зүйн яам, Хууль сахиулахын Их сургуулиас хамтран зохион байгуулсан **“Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдаж буй асуудал”** сэдэвт хэлэлцүүлэгт **“Төрийн тусгай чиг үүрэг бүхий албан хаагчийн хөдөлмөрийн маргааныг шүүхээр шийдвэрлэх зарим асуудал”** сэдвээр тус тус хичээл зааж болон илтгэл тавьж хэлэлцүүлжээ.



Шүүгч **Ц.Сумъяа** 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулиас зохион байгуулсан **“Монгол Улсын Хууль зүйн Шинжлэх ухааны өнөө ба ирээдүй”** сэдэвт онол, практикийн бага хуралд оролцжээ.

Шүүгч **Ч.Тунгалаг** 2015 оны 7 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсан Татварын итгэмжлэгдсэн няглан бодгчдын анхдугаар чуулганд оролцож, **“Татварын маргааныг шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал”** сэдвээр илтгэл хэлэлцүүлжээ.

Шүүгч **Ч.Тунгалаг** 2015 оны 9-10 дугаар сарын байдлаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хугацаа хэтэрсэн 256 хэргийг үзэж судалгаа гаргаж, танилцуулга бичсэн байна.

Шүүгч **П.Соёл-Эрдэнэ**:

- 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр **“Үндсэн хууль тайлбарлах онол, арга зүй”** сэдэвт;

- 2015 оны 5 дугаар сарын 08-ны өдөр Японы засгийн газрын **“Жайка”**-аас “Шударга өрсөлдөөний орчныг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Япон Улсын шударга өрсөлдөөний газрын төлөөлөгчдийн уулзалт-ярилцлага, онол практикийн бага хуралд оролцож болон хичээл заасан байна.

Шүүхийн тамгын газар

Тамгын газар нь хуульчийн гэрчилгээ бүхий захиргааны ажилтнуудыг 2015 оны кредит багц цагийн сургалтанд хамруулснаас гадна Архивын Ерөнхий газартай хамтарч **“Архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт”** сэдвээр, МУИС-тай хамтарч **“Монгол хэлний зөв бичгийн дүрэм, найруулга”** сэдвээр, Улсын Дээд шүүхийн мэдээлэл технологи хариуцсан референт Э.Баярбаатар **“Антивирусын програмын хэрэглээ”** **“Сүлжээ, сүлжээний орчин”** сэдвээр, компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан ахлах шинжээч С.Сундуйжав **“Мэдээллийн аюулгүй байдал, хэрэглээний програм”** сэдвээр сургалт тус тус зохион байгууллаа. Мөн **“Хан голомт”** төвтэй хамтарч хувь хүний болон байгууллагын хөгжлийн чиглэлээр 9 удаагийн сургалт, зөвлөх үйлчилгээнд захиргааны албан хаагчдыг хамруулжээ.

Мөн 2015 оны 1 дүгээр сарын 16-нд нийт шүүгч, ажилтнуудад Авлигатай тэмцэх газрын албан тушаалнаар **“Хөрөнгө орлогын болон ашиг сонирхлын мэдүүлэг хэрхэн гаргах”** талаар сургалтыг зохион байгуулсан байна.



Улирч буй 2015 онд бид амжилт бүтээл арвин байлаа. Ирж буй 2016 онд Монгол Улсад орчин цагийн шүүх байгуулагдсаны 105 жил, Улсын Дээд шүүхийн 90 жилийн ой тохиож буй түүхэн жил байх болно. Тиймээс бид шүүхийн шинэчлэл, шүүн таслах ажиллагааны чанар болон шүүхийн захиргааны удирдлагын шинэ бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг анхааран ажиллах нэн хариуцлагатай, түүхэн үүргийг хүлээж байна. Иймээс Та бүхнийг эрхэлсэн ажилдаа идэвхи санаачлага, итгэл зүтгэл, үр бүтээл гарган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэндээ шинэ жилийн баярын мэнд дэв шүүлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе.

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**

2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр